

Авлигатай тэмцэх газрын даргин  
2023 оны 12 дугаар сарын 26-ны  
өдрийн дугаар тушаалтын  
хавсралт

“ШУДАРГА ЁС” ОНОЛ, ПРАКТИК, АРГА ЗҮЙН  
СЭТГҮҮЛИЙГ ЭРХЛЭН ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ журмаар Авлигатай тэмцэх газрын “Шударга ёс” онол, практик, арга зүйн сэтгүүл (цаашид “сэтгүүл” гэх)-д нийтлүүлэх бүтээлд тавигдах шаардлага, сэтгүүлийн удирдлага зохион байгуулалт, сэтгүүлийг эрхлэн, хэвлэн түгээхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Сэтгүүл нь хууль зүйн шинжлэх ухааны онол, практик, арга зүйн мэргэжлийн хагас жил тутмын хэвлэл бөгөөд Монгол хэлээр “Шударга ёс” гэсэн нэртэй байна.

1.3 Сэтгүүлийн үүсгэн байгуулагч нь Авлигатай тэмцэх газар байх сэтгүүлийн нэрийг эзэмших эрх нь үүсгэн байгуулагчид хадгалагдана. Сэтгүүлийн үйл ажиллагаа ашгийн төлөө бус байна.

1.4 Сэтгүүл нь Авлигатай тэмцэх газрын өмч бөгөөд олон улсын стандартын сериал дугаар буюу ISSN (International Standard Serial Number) бүртгэлээр баталгаажсан болно.

1.5 Сэтгүүл нь цахим шуудангийн хаягтай байх бөгөөд цахим шуудангийн хаяг нь сэтгүүлийн оноосон нэрийг агуулсан байна. Сэтгүүл нь цахим сүлжээнд хуудастай байж болно.

Хоёр. Нийтлэлийн бодлого

2.1 Сэтгүүлийн нийтлэлийн бодлого нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, шударга ёсыг тогтоох чиглэлээр хэрэгжүүлж байгаа төрийн бодлого, үйл ажиллагаа, сайн туршлага болон судалгааны арга зүй, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэгдсэн нийтлэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, онол-арга зүйн бүтээлийг нийтэлж, олны хүртээл болгож, хууль зүйн шинжлэх ухааны ололтыг түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд иргэд, олон нийтийн авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэхэд оршино.

2.2 Сэтгүүлд нийтлэгдсэн эрдэм шинжилгээний бүтээл нь зохиогчийн оюуны өмч байх бөгөөд уг бүтээлийн ашиглалт, эрхийн хамгаалалт нь хууль тогтоомжид заасны дагуу хамгаалагдсан байна.

Гурав. Сэтгүүлийн удирдлага, зохион байгуулалт

3.1 Сэтгүүлийн удирдлагыг Сэтгүүлийн зөвлөл хэрэгжүүлнэ. Сэтгүүлийн зөвлөл нь дарга, гишүүн, нарийн бичгийн даргыг оролцуулан 9-өөс доошгүй гишүүнтэй байна.

3.2 Сэтгүүл нь эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, сэтгүүлд тавигдах бүтээлийг шинжлэх ухаан, онол, арга зүйн талаас нь хянан тохиолдуулах үүрэг бүхий Редакцийн зөвлөлтэй байна.

3.3 Сэтгүүлийн зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн бүрэлдэхүүн болон Редакцийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сэтгүүлийн зөвлөлөөс санал болгосноор Авлигатай тэмцэх газрын дарга томилж, чөлөөлнө.

3.4 Сэтгүүл нь зохион байгуулалтын хувьд ажлын албатай байж болно.

3.5 Сэтгүүлийн зөвлөлийн дарга нь зөвлөлийг тэргүүлэх бөгөөд сэтгүүлийн ажлын албатай бол сэтгүүлийг удирдах ажлаа тус албаар дамжуулан хэрэгжүүлж болно.

3.6 Сэтгүүлийн зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хагас жил тутамд нэг удаа Зөвлөлийн даргын зарласнаар хуралдана. Зөвлөлийн даргын зарласнаар ээлжит бус хуралдааныг зохион байгуулж болно. Хуралдаанд гишүүдийн

50 буюу түүнээс дээш гишүүд хүрэлцэн ирснээр хүчинтэй бөгөөд асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

### 3.7 Сэтгүүлийн зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.7.1 Нийтлэлийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих, сэтгүүлийг хөгжүүлэх бодлого, чиглэл батлах;

3.7.2 Сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүнээр ажиллах гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачийг сонгох, томилуулахаар санал болгох;

3.7.3 Сэтгүүлийн ажлын албаны бүтцийг тогтоох, түүнд дэмжлэг үзүүлэх;

3.7.4 Сэтгүүлийн нэр, бэлгэ тэмдэг, хавтас дизайныг батлах, өөрчлөх асуудлыг шийдвэрлэх;

3.7.5 Нийтлэлийн бодлого, эх бэлтгэлийн чанар болон бусад үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

3.7.6 Сэтгүүлийн дугаар тус бүрийн эцсийн төсөлтэй танилцан, хэвлэлтэд шилжүүлэх шийдвэр гаргах;

3.7.7 Редакцийн зөвлөлийн гишүүн, эрдэмтэн, судлаачдад олгох урамшуулал, мэргэжлийн түвшинд хөндлөнгийн дүгнэлт гаргах (peer review буюу реценз) эрдэмтэнд олгох ажлын хөлсний хэмжээг тогтоох, олгох эсэх талаарх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

3.8 Сэтгүүлийн зөвлөл нь сэтгүүлийн редакцийн зөвлөлд нийтлэлийн бодлого, бүтээлийн агуулгын талаар зөвлөгөө өгч болно.

3.9 Редакцийн зөвлөл нь сэтгүүлд чанартай бүтээл нийтлүүлэх зорилгоор нийтлэх бүтээлийг шинэлэг байдал шинжлэх ухаан, онол, арга зүй, баримт бичгийн боловсруулалт талаас нь хянаж, шаардлага хангах эсэх талаарх дүгнэлтийг бүтээлийг хэвлүүлэх эсэх талаарх саналын хамт сэтгүүлийн зөвлөлд өгнө.

3.10 Редакцийн зөвлөл нь бүтээлийг эрдэм шинжилгээний бүтээлийн хэмжээнд боловсруулагдсан эсэхийг тооцон хэвлүүлэх талаар мэргэжлийн түвшинд хөндлөнгийн дүгнэлт (peer review буюу реценз)-ийг гаргуулахаар, сэтгүүлийн чанар, өнгө үзэмж, агуулгатай асуудалтай холбоотой саналыг гаргаж болно.

## Дөрөв. Сэтгүүлд нийтлүүлэх бүтээлд тавигдах шаардлага

4.1 Сэтгүүлд энэхүү журмын “Хоёр” дугаар зүйлд заасан сэтгүүлийн бодлогын олон улсын болон үндэсний түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, зарчим, хөгжлийн чиг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны үр дүн, тойм, бүтээлийн шүүмж, танилцуулга, эсээ, шинжлэх ухааны тайлбар, мэдээлэл, ярилцлага, эх сурвалж, орчуулга, орчуулгын материал (цаашид “бүтээл” гэх) зэрэг шаардлага хангасан бүтээлийг нийтлнэ.

### 4.2 Сэтгүүлд дараах нийтлэг шаардлагыг хангасан бүтээлийг нийтлнэ. Үүнд:

4.2.1 Агуулгын хувьд зохиогчийн эрхийн болон ёс зүйн зөрчилгүй байх;

4.2.2 Бүтээлийн нэр, зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, албан тушаалыг монгол, англи хэл дээр бичсэн байх;

4.2.3 Бүтээлийн зохиогчийн зураг (300-аас доошгүй dpi нягтаршилтай, .jpg, .psd өргөтгөлтэй), цахим шуудан, холбоо барих утасны дугаарыг хавсаргасан байх;

4.2.4 Бүтээлийг MS Word программаар, үндсэн бичвэрийг Times New Roman, 11 pt, мөр хоорондын зайд 1 (single); эшлэл, зүүлтийг Times New Roman, 10 pt, мөр хоорондын зайд 1 (single) хэмжээтэй байхаар бичих бөгөөд (.docx) өргөтгөлтэй байх;

4.2.5 Бүтээл нь өмнө нь гадаад болон дотоодод хэвлэн нийтлэгдээгүй, нийтийн хүртээл болоогүй байх;

4.2.6 Хэл зүйн хувьд нийтлэлийн шаардлагыг хангасан байх;

4.2.7 Гадаад нэр томьёог галигласан бол хаалтад тухайн гадаад хэл дээрх нэр томьёог бичсэн байх;

4.2.8 Зураг, график схемийг цахим болон хэвлэмэл байдлаар ирүүлсэн байх.

4.3 Сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлсэн бүтээл нь энэ журмын 4.2-т заасан шаардлагыг хангахгүй бол сэтгүүлийн редакцийн зөвлөл шаардлага хангуулахаар зохиогчид буцаах ба дахин шаардлага хангахгүй бүтээл ирүүлсэн бол хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.

4.4 Эрдэм шинжилгээний өгүүлэл (цаашид "өгүүлэл"гэх) авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх, шударга ёсны талаарх онолын болон практикийн тулгамдсан асуудлыг хөндсөн, хандлага зохицуулалтыг харьцуулан авч үзсэн, эсхүл шийдэл эрэлхийлсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй санал, дүгнэлт гаргасан, зохиогчийн эрхийг хүндэтгэсэн, судалгааны ач холбогдолтой байна.

4.4.1 Өгүүлэл дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1/ Гарчиг (Монгол, Англи хэлээр);
- 2/ Түлхүүр үгс /Монгол, Англи хэлээр/;
- 3/ Товчлол (Монгол, Англи хэлээр);
- 4/ Үндсэн хэсэг;
- 5/ Дүгнэлт, санал;
- 6/ Эх сурвалж;
- 7/ Хавсралт;

4.4.2 Өгүүлэл нь гарчиг, түлхүүр үгс, товчлол, эх сурвалжийн жагсаалт, хавсралтаас гадна 2500-3750-аас доошгүй үтгэй байна.

4.4.3 Түлхүүр үгс нь 5 хүртэлх тооны холбоо үгээс бүрдэх ба бүтээлийн гарчигт ороогүй үгээс бүрдсэн байна.

4.4.4 Товчлол нь англи, эсвэл орос хэлээр бичигдсэн, 150 хүртэл үгэнд багтсан байна.

4.4.5 Үндсэн хэсэгт гадаад, дотоодын онолын болон эрдэмтдийн бүтээл, тохиолдол (англи. case) ашиглан дэвшүүлсэн санаагаа илэрхийлэх, өөрийнх биш санаа, өгүүлбэрт эшлэл заавал авсан байна.

4.4.6 Дүгнэлт, саналыг бичихдээ үндсэн хэсэгт дурдаагүй шинэ санаа оруулахгүй бөгөөд дэвшүүлсэн асуудлаа шийдвэрлэх арга зам санал болгосон байвал зохино.

4.4.7 Эрдэм шинжилгээний өгүүллийг англи, орос хэлээр хэвлэж болно

4.4.8 Ашигласан эх сурвалжаас заавал эшлэл авсан байна.

4.5 Судалгааны үр дүн, тойм гэдэгт эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн-тайлан, танилцуулга, тойм, хураангуй зэргийг ойлгоно.

4.5.1 Судалгааны үр дүн, тойм нь эрдэм шинжилгээний өгүүлэлтэй нэгэн адил хэлбэрийн шаардлагыг хангасан байна.

4.5.2 Судалгааны үр дүн, тойм нь хураангуй, түлхүүр үг, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, зөвлөмж, ном зүйн жагсаалтыг оролцуулалгүйгээр 1000-4000 хүртэл үтгэй байна.

4.5.3 Тухайн сэдвээр судлаачдын бүтээл, номлогоос эшлэл авсан байна.

4.6 Бүтээлийн шүүмж, танилцуулга

4.6.1 Бүтээлийн шүүмжийг зохиогчоос өөр судлаач, бүтээлийн танилцуулгыг тухайн судлаач өөрөө, эсхүл өөр судлаач бичсэн байна.

4.6.2 Шүүмж нь тухайн бүтээлийн шинжлэх ухаанд оруулж байгаа хувь нэмрийг дурьдахаас гадна өмнөх бүтээл, эрх зүйн номлол, онол, практикийг өөрчилж байгаа байдал, хэрхэн холбосныг илэрхийлсэн байна.

4.6.3 Шүүмж бичих бүтээл нь магистр, докторын судалгааны ажлаас бусад эрдэм

шинжилгээний бүтээл байна.

4.6.4 Шүүмжийг бүтээл хэвлэгдсэнээс хойш 6 сараас доошгүй хугацааны дараа нийтэлж болно.

4.6.5 Бүтээлийн танилцуулга, шүүмж нь 1000-3000 үgtэй байна.

#### 4.7 Эсээ

4.7.1 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх, шударга ёсны асуудалд шинжлэх ухаанчаар хандаж, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, өөрийн үзэл бодол, чөлөөт сэтгэлгээний хүрээнд тоон мэдээлэл, эшлэл, зүүлтээр санаагаа бататган илэрхийлсэн бүтээл байна.

4.7.2 Эсээ нь 2000-4000 үgtэй байна.

4.8 Шинжлэх ухааны тайлбар нь ойлголт, нэр томьёо, утга агуулгыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, нэг мөр ойлголт өгөхийг зорьсон 700-аас доошгүй үgtэй байна.

4.9 Мэдээлэл-Гадаад, дотоодод өрнөсөн цаг үе, үйл явдлын тухай мэдээлэл байна.

4.10 Ярилцлага нь найруулга зүй, хэлзүйн шаардлага хангасан, бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэсэн байна.

4.11 Эх сурвалж, орчуулга:

4.11.1 Сэтгүүлд хэвлэн нийтлэх ач холбогдлыг харгалзан нэг удаагийн дугаарт нэгээс илүүгүй ховор, нэн шаардлагатай материалын эх сурвалж, орчуулгыг нийтэлж болно.

4.11.2 Редакцийн зөвлөл эх сурвалж, орчуулгын үнэн зөв эсэхийг нягтлах бөгөөд нийтлэхээс татгалзах эрхтэй.

4.11.3 Эх сурвалж, орчуулгыг ирүүлэхдээ эх материалыг хаана, хэзээ хэвлэгдсэнийг таньж болохуйц байдлаар хавсарган ирүүлнэ.

#### Тав. Бүтээл хүлээн авах

5.1 Энэ журамд заасан шаардлагыг хангасан бүтээлийг бүтээлийн зохиогч биечлэн эсхүл байгууллагын албан ёсны цахим шуудангийн хаяг, шуудангийн хаягаар А4 хэмжээгээр хэвлэмлээр болон цахим хэлбэр (зөөврийн цахим хэрэгсэл)-ээр ирүүлнэ.

5.2 Бүтээлийг сэтгүүлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга бүтээлийг хүлээн авсан он, сар, өдөр, цаг, бүтээлийн нэр, хуудасны тоо, хүлээлгэн өгсөн хүний нэр, хүлээн авсан хэлбэрийг тэмдэглэж, ирүүлсэн хугацааны дарааллаар хүлээн авсан бүртгэлд бүртгэнэ.

5.3 Биечлэн ирсэн тохиолдолд хүлээлгэн өгсөн хүн гарын үсэг зуруулна.

5.4 Энэ журмын 5.2-т зааснаар бүртгэсэн тухай зохиогчид мэдэгдэнэ.

#### Зургаа. Бүтээлийг Редакцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх

6.1 Энэ журмын "Тав" дугаар зүйлд зааснаар хүлээн авсан бүтээлийг сэтгүүлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга Редакцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангана.

6.2 Редакцийн зөвлөл жилд 2 удаа буюу жил бүрийн 5, 11 дүгээр сард хуралдаж, журмын 3.9-д зааснаар бүтээлийг мэргэжлийн түвшинд хянан редакторлаж, шаардлага хангах эсэх талаарх дүгнэлтийг бүтээлийг хэвлүүлэх эсэх талаарх саналын хамт сэтгүүлийн зөвлөлд шилжүүлнэ.

6.3 Нийтлэхээс татгалзсан бүтээлийг сэтгүүлийн редакцийн зөвлөл хадгалахгүй.

6.4 Сэтгүүлд нийтлэгдсэн үзэл, бодол мэдээллийн үнэн зөв байдлыг зохиогч өөрөө хариуцна.

6.5 Бүтээлийг уншиж, хянан тохиолдуулсан Редакцийн гишүүн, эрдэмтэн, судлаачдад жилийн эцэст зохих хэмжээний урамшуулал олгож болно.

## Долоо. Хөндлөнгийн дүгнэлт гаргах

7.1 Бүтээлийг эрдэм шинжилгээний бүтээлийн хэмжээнд боловсруулагдсан эсэхийг тооцон хэвлүүлэх талаар мэргэжлийн түвшинд хөндлөнгийн дүгнэлт (peer review буюу реценз)-ийг гаргуулж болно.

7.2 Сэтгүүлд хэвлэх бүтээлийг зохиогч хүсэлт гаргасан, эсхүл редакцийн зөвлөлийн гишүүн санал болгосон бөгөөд зохиогч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд бүтээлд тусгагдсан асуудлаар мэргэшсэн, хянан дүгнэлт гаргах чадвар туршлагатай 1-3 эрдэмтэн (Sc.D, Ph.D)-ээр дүгнэлт гаргуулахаар Сэтгүүлийн зөвлөл шийдвэрлэнэ.

7.3 Сэтгүүлийн зөвлөлөөс хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсэн бүтээлийг нэр хаяггүйгээр илгээж “хэвлэх”, “эс хэвлэх”, “нөхцөлтэйгөөр хэвлэх” саналын аль нэгийг албан ёсоор гаргуулна.

7.4 Хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг харгалзан “эс хэвлэх” саналтай бүтээлийг зохиогчид үндэслэлийг тайлбарлан буцааж, “хэвлэх”, “нөхцөлтэйгөөр хэвлэх” дүгнэлттэй бүтээлийг хэвлүүлэх эсэх талаар санал авахаар мэдэгдлийг хүргүүлнэ.

7.5 Зохиогч зөвшөөрсөн тохиолдолд “хэвлэх” дүгнэлттэй бүтээлийг шууд, “нөхцөлтэйгөөр хэвлэх” дүгнэлттэй бүтээлийг тухайн дүгнэлтэд заасан ажиллагааг бүрэн хийсэн эсэхийг Редакцийн зөвлөл хянаж, шаардлага хангаж байна гэж үзвэл хэвлүүлнэ.

7.6 Дүгнэлт гаргасан эрдэмтэнд урамшуулал олгож болох бөгөөд урамшууллын жишгийг Сэтгүүлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Дүгнэлт гаргуулж буй зохиогч дүгнэлт гаргуулах зардлыг өөрөө хариуцна.

Найм. Сэтгүүлийг түгээх, олон нийтэд таниулах

8.1 Сэтгүүлийг хэвлэлтээс хүлээн авах, түгээх ажлыг сэтгүүлийн нарийн бичгийн дарга хариуцна.

8.2 Сэтгүүлийн нэг хувийг Судалгаа шинжилгээний алба жил бүрийн дараа оны 1 дүгээр улиралд багтаан байгууллагын архивт бүртгэлээр хүлээлгэн өгнө.

8.3 Хэвлэлтээс гарсан сэтгүүлийг ажлын 5 өдөрт багтаан хэлтэс, албадын дарга нарт, ажлын 10 өдрийн дотор УИХ, Засгийн газар, Хууль зүйн яам, хууль сахиулах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, их, дээд сургууль, судалгааны байгууллагуудад бүртгэлээр түгээнэ.

8.4 Цахим хувилбарыг байгууллагын албан ёсны цахим хуудсанд байршуулж болно.

8.5 Бүтээлээ хэвлүүлсэн зохиогчид тухайн дугаарын сэтгүүлийн нэг хувийг үнэгүй олгоно.